



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 19 он 12  
сарын 02 өдөр

Дугаар ЗГ-1/185

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



У.ХҮРЭЛСҮХ

0003490



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 19 он 11 дугаар  
сарын 21-ны өдөр

Дугаар ХЭГ/3276

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тов тогтоох тухай

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



 Л.ОЮУН-ЭРДЭНЭ


0014007

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 54 дүгээр тэмдэглэлд:

"I.ХЭЛЭЛЦСЭН нь: Өрсөлдөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Өрсөлдөөний тухай /Шинэчилсэн найруулга/ болон дагалдах бусад хуулийн төслүүдийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
<http://www.mojha.gov.mn>

2019.01.25 № 1-1/406  
танай 2019.01.12-ны № 37/2-37-т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР  
САЙД Ө.ЭНХТҮВШИН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

  
Ц.НЯМДОРЖ

151600253

Бое. урл 13-2019



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.09.07 № 6/6940


танай 2019.08.20-ны № Д-2/665-Т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
Ө.ЭНХТҮВШИН ТАНАА**

Өрсөлдөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл хүссэн 2019 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн ЗГ-2/665 дугаартай албан бичигтэй танилцлаа.

Сангийн сайдын 2018 оны 6/6672, 2019 оны 6/902 дугаартай албан бичгээр хуулийн төсөлд тусгагдсан төрийн албаны орон тоо, төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэх үр дагавартай 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг хасах санал хүргүүлж байсан.

Дахин санал авахаар ирүүлсэн хуулийн төсөлд дээрх хэсгийг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Өрсөлдөөний тухай хуулийн холбогдох заалтыг хэвээр үлдээх байдлаар төсөвт нэмэлт орон тоо, ачаалал үүсгэхгүйгээр боловсруулан ирүүлсэн байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

0001003



**МОНГОЛЫН АЖИЛ ОЛГОГЧ  
ЭЗДИЙН НЭГДСЭН ХОЛБОО**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сүхбаатарын талбай - 18,

Таван Богд плаза төв, 1 давхар

Утас: 326 445, 326513, Факс: (976-11) 325 524,

E-mail: monef@magicnet.mn, <http://www.monef.mn>

2019.10.09

№ 04/113

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН ХЭРЭГЛЭГЧИЙН  
ТӨЛӨӨ ГАЗРЫН ДАРГА Б. ЛХАГВА ТАНАА

Монгол Улсын "Өрсөлдөөний тухай хууль" –д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг МАОЭНХолбоо болон түүний гишүүд дэмжигчид бүрэн дэмжиж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Хуулийн төслийг ажил олгогч эзэд болон бизнес эрхлэгчдээр хэлэлцүүлэх явцад гарсан санал дүгнэлтүүдийг хуулийн төсөлд тусгасан явдалд туйлын талархалтай байгаагаа илэрхийлж байна. Хуулийн төслийг Засгийн Газраар хэлэлцүүлэн

Улсын Их Хурлаар яаралтай хэлэлцүүлэхэд анхаарал хандуулж өгөхийг Таниас хүсье.

Хүндэтгэсэн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Х. ГАНБААТАР

